

Монгол Улс, Бүгд Найрамдах Энэтхэг улс хоорондын Стратегийн түншлэлийг улам бэхжүүлэх тухай Хамтарсан мэдэгдэл

Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулгын Бүгд Найрамдэх Энэтхэг улсад хийсэн Төрийн айлчлал, Монгол Улсын Ерөнхийлөгчийн БНЭУ-ын Ерөнхийлөгч Рам Натх Ковинд, тус улсын Ерөнхий сайд Нарендра Модитой уулзсан уулзалтын дүнд “Монгол, Энэтхэгийн Стратегийн түншлэлийг улам бэхжүүлэх тухай хамтарсан мэдэгдэл”-ийг гаргаж байна.

Монгол, Энэтхэгийн стратегийн түншлэлийг улам бэхжүүлэх тухай хамтарсан мэдэгдэл:

1. Айлчлалын үеэр Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Ерөнхийлөгч Рам Натх Ковиндтой уулзаж, Ерөнхий сайд Нарендра Модитой албан ёсны хэлэлцээ хийв. Уулзалт, яриа хэлэлцээ илэн далангүй, нөхөрсөг, дотно уур амьсгалд болж өнгөрөв. Яриа хэлэлцээний үеэр хоёр талын болон харилцан сонирхсон бүс нутаг, олон улсын асуудлуудаар санал солилцов.
2. Энэтхэг Улсын Ерөнхий сайд Нарендра Моди 2015 онд Монгол Улсад түүхэн айлчлал хийснийг талууд онцлов. Энэхүү айлчлалын үеэр улс орнуудын тусгаар тогтнол, бүрэн эрх, эрх тэгш байдлыг хангах нийтлэг зарчим, Монгол Улс, Бүгд Найрамдах Энэтхэг Улсын хооронд 1994 оны 2 дугаар сарын 22-нд байгуулсан Найрсаг харилцаа, хамтын ажиллагааны Гэрээний үндсэн үзэл санаа болон бусад хоёр талын баримт бичгүүдэд суурилан Монгол, Энэтхэгийн харилцааг Стратегийн түншлэлийн түвшинд хүргэхээр тохирсныг талууд тэмдэглэв.

3. Соёл иргэншил, түүх, оюун санаа, соёлын хэлхээ холбоо, мөн ардчилал, эрх чөлөөг эрхэмлэсэн нийтлэг үнэт зүйлстэй орнуудын хувьд Стратегийн түншлэлийн харилцаагаа улам өргөжүүлэн бэхжүүлэхийг талууд нотлов. Монгол Улс өөрийн чухал гуравдагч хөрш болох Энэтхэг Улстай хөгжүүлж буй харилцаа, хамтын ажиллагаанд өндөр ач холбогдол өгдөгөө дахин нотлов.
4. Талууд 2015 оноос хойш төр засгийн дээд удирдлага болон ажил хэргийн түвшинд харилцан айлчлалын давтамж тогтмолжсонд сэтгэл хангалиун буйгаа илэрхийлж, Стратегийн түншлэлийн нөөц бололцоог бүрэн ашиглах зорилгоор цаашид дээд, өндөр түвшний айлчлал болон парламентын гишүүд, ахлах албан тушаалтнуудын солилцоог үргэлжлүүлэн хэрэгжүүлэхээр тохиролцов.
5. Талууд хоёр талын харилцааг өргөжүүлэхэд байгууллага хоорондын харилцааны механизмуудын тогтмол уулзалтууд чухал үүрэг гүйцэтгэж ирснийг онцлон тэмдэглэв. Талууд харилцан сонирхсон бүхий л асуудлын явц байдалд үнэлгээ хийх, шинэ салбаруудын хамтын ажиллагааг өргөжүүлэхэд энэ төрлийн яриа хэлэлцээг тогтмол зохион байгуулах нь чухал ач холбогдолтой гэдэгт санал нэгдэв. Энэ хүрээнд Монгол, Энэтхэгийн Засгийн газар хоорондын Хамтарсан хорооны ээлжит хуралдааныг Шинэ Дели хотноо харилцан тохиромжтой цагт зохион байгуулахаар тогтов.
6. Талууд олон улс болон бүс нутгийн аюулгүй байдлын чухал асуудлуудаар ижил төстэй байр суурьтай буйг тэмдэглээд, шинээр гарч ирж буй тулгамдсан асуудал, сорилтуудыг шийдвэрлэхийн тулд цаашид ч бүс нутгийн болон олон талт хамтын ажиллагааны хүрээнд харилцан бие биеэ дэмжих уламжлалаа үргэлжлүүлэх, аюулгүй байдлыг хамгаалах субъектуудын хамтын ажиллагааг эрчимжүүлэхээ нотлов.
7. Талууд Нэгдсэн Үндэстний Байгууллага болон түүний үндсэн нэгжүүдийг илүү ардчилсан, төлөөлөл сайтай,

нээлттэй, үр ашигтай болгохын төлөөх шинэчлэлийн үйл явцыг дэмжиж буйгаа илэрхийлэв. Талууд НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн байнгын болон байнгын бус гишүүнчлэлийн ангиллыг өнөөгийн бодит байдал болон чиг үүрэгт хариуцлагатай, төлөөлөлтэй, үр дүнтэй байдлаар нийцүүлэн шинэчлэхийн чухлыг онцлов. НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлд байнгын гишүүнээр элсэх Энэтхэг Улсын хүч чармайлтыг Монголын тал дэмжихээ дахин илэрхийлэв. Талууд НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн 2021-2022, 2023-2024 оны Байнгын бус гишүүний сонгуулиудад харилцан бие бие дэмжихээ дахин нотлов.

8. Талууд хэт даврах үзэл (экстремизм) болон терроризм нь нийт хүн төрөлхтөнд томоохон аюул заналхийлэл болоод буйг хүлээн зөвшөөрч, терроризмын бүхий л хэлбэр, илэрхийллийг эрс буруушааж буйгаа дахин илэрхийлэв. Талууд терроризмыг ямар ч үндэслэлээр зөвтгөх боломжгүй бөгөөд аливаа шашин, итгэл үнэмшил, үндэс угсаа, гарал үүсэлтэй холbon уях учиргүйг дахин нотлов. Талууд терроризмыг таарсан газар бүрт шийдэмгий нухчин дараахаа хатуу илэрхийлж, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх хүчин чармайлтаа бэхжүүлэхийг олон улсын хамтын нийгэмлэгт уриалан, террористуудын орогнож буй газрууд болон үйл ажиллагааг устгахад шийдэмгий алхам хийх нь зүйтэй гэдэгт санал нэгдэв. Энэтхэг Улс, Монгол Улс энэ чиглэлээр, түүний дотор Олон улсын терроризмын иж бүрэн Конвенцийг эцэслэх асуудалд хамтарч ажиллахаа дахин нотлов.
9. Талууд терроризм, хүч хэрэглэсэн хэт даврах үзэл зэрэг сорилтыг үр дүнтэй шийдвэрлэх зорилгоор хөгжиж буй орнуудын терроризмын болон зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх чадавхыг олон улсын хамтын нийгэмлэгтэй хамтран нэмэгдүүлэх шаардлагатайг онцлов.
10. Талууд зохион байгуулалттай гэмт хэрэг, мөнгө угаах,

терроризмыг санхүүжүүлэх болон түүнтэй холбоотой гэмт хэрэг нь санхүүгийн тогтвортой байдалд ноцтой аюул учруулж байгааг ухамсарлаж, бус нутгийн эдийн засгийн аюулгүй байдлыг хангах, үндэсний банк, санхүүгийн тогтолцоог гэмт этгээд хууль бусаар ашиглахаас хамгаалах үүрэгтэйг дахин нотлов. Талууд мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх асуудлаар олон улсын өргөн хүрээтэй хамтын ажиллагаа өрнүүлэхийн ач холбогдлыг хүлээн зөвшөөрч, Олон улсын санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллагын зөвлөмжийн үндсэн дээр зохион байгуулалттай гэмт хэрэг, мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр тууштай ажиллахаа илэрхийлэв.

11. Энэтхэгийн тал “Энэтхэг, Номхон далайн үзэл санаа” санаачилгаа танилцуулж, энэхүү үзэл санаа нь Энэтхэг, Номхон далайн бус нутагт олон улсын хууль, дурмийн удирдлага дор тус бус нутаг дахь бүхий л улсуудын хамтын хүчин чармайлтын үндсэн дээр, тухайн улсуудын хууль ёсны эрх ашигт нийцсэн, нээлттэй, чөлөөтэй бөгөөд хүртээмжтэй бүтцийг цогцлооход оршино хэмээн тайлбарлав.

Монголын тал “Энэтхэг, Номхон далайн үзэл санаа”-г хамтын хүчин чармайлтад суурилан Энэтхэг, Номхон далайн бус нутагт тогтвортой байдал болоод бүхий л улсад хүртээмжтэй хөгжил цэцэглэлийг авч ирэхэд чиглэсэн хэмээн үзэж, дэмжиж буйгаа илэрхийлэв. Мөн хувьсан оөрчлөгдж буй Энэтхэг, Номхон далайн бус нутаг дахь интеграцчлал, түүний дотор Зүүн Азийн дээд түвшний уулзалтад идэвхтэй оролцох сонирхлоо нотлов.

Талууд чөлөөтэй, нээлттэй, хөгжингүй бөгөөд хүртээмжтэй Энэтхэг, Номхон далайн бус нутаг нь тус бус нутгийн бүх орны төдийгүй дэлхий дахинь урт хугацааны эрх ашигт нийцнэ гэдэгт санал нэгдэв.

12. Талууд үндэсний аюулгүй байдал, батлан хамгаалах болон хил хамгаалах салбарын хамтын ажиллагаа хоёр улсын харилцаа Стратегийн түншлэлийн түвшинд хүрснээс хойши хугацаанд улам өргөжиж буйд сэтгэл хангалуун байгаагаа тэмдэглэв. Талууд эдгээр салбарын өндөр түвшний харилцан айлчлалууд, түүний дотор Монгол Улсын Батлан хамгаалахын сайдын Энэтхэг Улсад, Энэтхэг Улсын Дотоод хэргийн сайдын Монгол Улсад хийсэн айлчлал болон хоёр улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөл хоорондын тогтмол харилцаа, хамтын ажиллагаа чухал ач холбогдолтой болохыг онцлон тэмдэглэж, үндэсний аюулгүй байдлыг хамгаалах хамтын ажиллагааг шинэ түвшинд өргөжүүлэхээр тохиролцов.
13. Талууд Энэтхэг Улсад зохион байгуулдаг “Нүүдэлчин заан”, Монгол Улсад зохион байгуулдаг “Хааны эрэлд” зэрэг цэргийн хамтарсан сургуулилтад хоёр орны зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүн тогтмол оролцдогийг сайшаав. Талууд цаашид батлан хамгаалахын салбарын сургалт, солилцооны хамтын ажиллагааг өргөжүүлэхээр тохиролцов.

Цэргийн буцалтгүй тусlamж үзүүлэх, батлан хамгаалах салбарын ажилтан, албан хаагчдыг сургах зэргээр Монголын Зэвсэгт хүчний чадавхыг бэхжүүлэхэд Энэтхэгийн талаас дэмжлэг туслалцаа үзүүлж байгаад Монголын тал талархал илэрхийлэв. Энхийг сахиулах чиглэл дэх хамтын ажиллагааг гүнзгийрүүлэх сонирхлоо Монголын тал илэрхийлэв.

14. Талууд хил хамгаалах, хилийн менежментийн чиглэлийн хамтын ажиллагаа, ялангуяа Монгол Улсын Хил хамгаалах ерөнхий газар, Энэтхэг Улсын Хил хамгаалах хүчин хоорондын хамтын ажиллагааг онцолж, цаашид улам бэхжүүлэхээр тохиров.
15. Талууд Энэтхэгийн тусламжаар Монгол Улсад Кибер аюулгүй байдлын сургалтын төвийг байгуулах төслийн

явлц ахицтай байгааг тэмдэглэв. Энэтхэгийн тал кибер аюулгүй байдлын салбарт чадавхыг бэхжүүлэх, дэд бүтцийг хөгжүүлэхэд Монголын талд дэмжлэг үзүүлэхээ дахин нотлов.

16. Талууд хоёр талын худалдаа, хөрөнгө оруулалт, нэн ялангуяа хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн, сүү, сүүн бүтээгдэхүүн, мал аж ахуй, уул уурхай, мэдээллийн технологи, эмийн үйлдвэрлэл болон аялал жуулчлалын зэрэг салбарт хамтын ажиллагааны ихээхэн нөөц бололцоо байгаад санал нийлэв. Энэ хүрээнд талууд малын эрүүл мэнд, сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, туршлага болон технологи солилцох чиглэлээр хамтран ажиллах тухай иж бүрэн ажлын төлөвлөгөөнд гарын үсэг зурсныг сайшаан тэмдэглэв.
17. Хоёр талын хөрөнгө оруулалтыг дэмжихийн тулд хөрөнгө оруулалтын таатай орчинг бүрдүүлэхийн чухлыг талууд онцлон тэмдэглээд, Хөрөнгө оруулалтыг хөхиүүлэн дэмжих, харилцан хамгаалах хоёр талын хэлэлцээрийг байгуулах, Орлого ба хөрөнгийн татварыг давхардуулж ногдуулахгүй байх, татвар төлөхөөс зайлсхийх явдлаас урьдчилан сэргийлэх тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрт нэмэлт өөрчлөлтийг аль болох шуурхай оруулах тухай яриа хэлэлцээг үргэлжлүүлэхээр санал нэгдэв.
18. Энэтхэг Улсын Засгийн газрын 1 тэрбум ам.долларын зээлийн шугамын хүрээнд “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” төсөл урагшлан хэрэгжиж байгаад Монголын тал сэтгэл хангалуун буйгаа илэрхийлэв.

Энэтхэгийн тал түүхий эдийн тээвэрлэлтийн арга хэрэгслийг Газрын тос боловсруулах үйлдвэрийн бүтээн байгуулалт дуусгавар болохоос өмнө эцэслэсэн байх нь чухал болохыг дахин онцлов. Газрын тос боловсруулах үйлдвэрийн нарийвчилсан Техник эдийн засгийн үндэслэлд

тусгагдсаны дагуу тус төслийг амжилттай хэрэгжүүлэхэд түүхий эд тээвэрлэлтийн арга хэрэгслийг эцэслэн шийдвэрлэж ашиглалтад оруулсан байх нь нэн чухал гэдэгт Монголын тал санал нэгдэв.

Талууд энэхүү төсөл нь Монгол Улсын эрчим хүчний аюулгүй байдал болон эдийн засгийн өсөлтийг хангахад томоохон хувь нэмэр оруулна гэдэгт санал нэгдэв.

19. Энэтхэгийн тал уг төсөлд 236 сая ам.долларын зээлийг нэмэлтээр олгох тухай Монгол Улсын Засгийн газрын хүсэлтийг хүлээн авснаар Энэтхэг Улсын Засгийн газраас уг төсөлд нийт 1.236 тэрбум ам.долларын санхүүжилтийг хийхээр тогтов.
20. Талууд “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр”-т нэн шаардлагатай буй инженер болон техникийн ажилтнуудыг Энэтхэг Улсын Засгийн газрын тэтгэлгээр Техник, эдийн засгийн хамтын ажиллагааны хөтөлбөр (ITEC)-ийн хүрээнд сургахаар тогтов.
21. Талууд уур амьсгалын өөрчлөлтийн улмаас үүсч буй сорилтуудыг харгалzan сэргээгдэх эрчим хүчний салбарын хамтын ажиллагааг цаашид бэхжүүлэхээр тохиролцов. Түүнчлэн Олон улсын нарны холбоо (ОУНХ)-ны гишүүнчлэл халуун бус бүсийн НҮБ-ын гишүүн орнуудад нээлттэй болсныг Монгол Улс талархан хүлээн авч, тус холбоонд элсэх сонирхлоо илэрхийлэв. Энэтхэгийн тал Олон улсын нарны холбооны Ерөнхий хэлэлцээрийн нэмэлт, өөрчлөлтийг ОУНХ-ны гишүүн орнууд баталсны дараа уг хэлэлцээрт нэгдэх асуудлыг судалж үзэхийг санал болгов.
22. Монголын тал Энэтхэгийн “нарны дээвэр” төслийн хэрэгжилтийн туршлагаас судлах, Монголын сэргээгдэх эрчим хүчний салбарын мэргэжилтнүүдийг Энэтхэгт сургах сонирхлоо илэрхийлэв.

23. Энэтхэгийн Засгийн газар Монгол Улсын Гадаад харилцааны яамны барилгыг ногоон, нарны эрчим хүчний үр ашигтай хэрэглээ бүхий барилга болгон шинэчлэх ажилд дэмжлэг туслалцаа үзүүлэх шийдвэр гаргасныг зарлав.
24. Энэтхэг Улсын дэмжлэг туслалцаатайгаар Монгол Улсад Атал Бихари Важпайн нэрэмжит Мэдээлэл, харилцаа холбооны технологийн төвийг байгуулах ажлын явцыг талууд хэлэлцэв. Энэхүү төсөл Монгол Улсын хүний нөөцийн хөгжил, чадавхыг бэхжүүлэхэд чухал ач холбогдолтойг харгалzan хэрэгжилтийг нь эрчимжүүлэхээр талууд тохиролцов.
25. Талууд гамшигийн менежмент нь хамтын ажиллагааны чухал салбар болохыг онцолж, Монгол Улсын Онцгой байдлын ерөнхий газар, Энэтхэг Улсын Үндэсний Гамшигийн удирдлагын газар хооронд “Гамшигийн менежмент, гамшигийн эрсдлийг бууруулах салбарт хамтран ажиллах тухай харилсан ойлголцлын санамж бичиг”-т гарын үсэг зурсныг сайshaан тэмдэглэв. Түүнчлэн 2018 онд Монгол Улсад болсон байгалийн гамшигийн үеэр Энэтхэг Улсаас хүмүүнлэгийн тусламж үзүүлсэнд Монголын тал талархал илэрхийлэв.
26. Сансрыйн уудмыг энхийн зорилгоор судлах, ашиглах чиглэлээр хамтран ажиллах тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрт гарын үсэг зурсныг сайshaан тэмдэглэж, энэ нь алсын зайнаас мэдрэх, хиймэл дагуулын харилцаа холбоо болоод сансрыйн технологийг нөөцийн менежмент, цаг агаарын урьдчилсан мэдээ, гамшигийн менежмент болон бусад чиглэлээр ашиглах зэрэгт харилцан ашигтай хамтын ажиллагааг өргөжүүлэх үндэс суурь болохыг онцлов.
27. Ерөнхийлөгч Х.Баттулга, Ерөнхий сайд Н.Моди нар Бурхан багш Будда болон түүний шавь нарын сэргэг дүрийг

Улаанбаатар хот дахь Гандантэгчэнлийн хийдэд ёслол хүндэтгэлтэйгээр залж, энэхүү дурсгал нь хоёр улсын буддын шашны хамтын өв уламжлалын илэрхийлэл, хоёр улсын ард түмний оюун санааны эв нэгдлийн мөнхийн бэлгэдэл болно гэдгийг онцлон тэмдэглэв.

28. Талууд хоёр улсын Буддын шашны хэлхээ холбоог сэргээхэд чухал үүрэг гүйцэтгэсэн Кушок Бакула Римбүчигийн мэндэлсний 100 жилийн ойг амжилттай зохион байгуулсныг өндөрөөр үнэлэв. Энэтхэгийн тал энх тайван, ах дүүсийн барилдлагын үзэл санааг түгээн дэлгэрүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэдэг Азийн буддистуудын энх тайвны Бага хурал болон Самгад яриа хэлцээний З дахь удаагийн уулзалтыг Улаанбаатар хотод амжилттай зохион байгуулсанд Монголын талд баяр хүргэв.
29. Талууд Буддын шашны түүхэн уламжлалт харилцаа нь хоёр улсын харилцаа, хамтын ажиллагааны үнэт зүйл болохыг тэмдэглэж, цаашид бэхжүүлэн хөгжүүлэхээр тохиролцов.

Хоёр орны хоорондох соёл иргэншлийн хэлхээ холбоог тодорхойлох судалгаа хийж, дэлхий дахинд сурталчлахаар хоёр тал тохиром.

30. Энэтхэгийн тал Буддын шашны нийтлэг өвийг хадгалах, таниулах зорилтын хүрээнд Монгол Улсын Үндэсний номын сан зэрэг Монголын талын байгууллагуудад хадгалагдаж буй Буддын шашны гар бичмэлүүдийг цахимжуулахад дэмжлэг үзүүлэх саналаа дахин нотолсныг Монголын тал талархан хүлээн авав.
31. Талууд хоёр талын Стратегийн түншлэлийн цар хүрээг өргөжүүлэх зорилгоор иргэд хоорондын солилцоог цаашид нэмэгдүүлэх, визийн дэглэмийг хялбаршуулах чиглэлээр харилцан хийж буй алхмыг өндөрөөр үнэлэв. Энэтхэгийн тал богино хугацаагаар зорчигч Монгол иргэдийг цахим визийн үйлчилгээнд хамруулах шийдвэр гаргасанд Монголын тал

талаархал илэрхийлэв. Монголын тал аялал жуулчлалыг дэмжих хүрээнд богино хугацаагаар зорчигч Энэтхэгийн иргэдэд хил дээр виз олгож эхэлснийг зарлав.

32. Оюутан, залуусын солилцоог хөхиулэн дэмжих хүрээнд Энэтхэгийн тал Буддын шашны судлалаар Энэтхэгт суралцах хүсэлтэй Монгол оюутнуудад Энэтхэгийн Соёлын харилцааны зөвлөл (ICCR)-ийн арван тэтгэлэг, Монголын тал Монгол судлалд сонирхолтой Энэтхэг оюутнуудад хоёр тэтгэлгийг тус тус олгохоо зарлав.
33. Ерөнхий сайд Н.Моди Монгол Улсад айлчлах үеэр байгуулсан “Уламжлалт анагаах ухаан, гомеопати буюу эмийн бус эмчилгээний салбарт хамтран ажиллах тухай харилцан ойлголцлын санамж бичиг” ахицтай хэрэгжиж байгааг талууд тэмдэглээд, энэ салбар дахь хамтын ажиллагааг улам эрчимжүүлэхээр тохиролцов.
34. Талууд хоёр орны хооронд дипломат харилцаа тогтоосноос хойш 64 жилийн түүхэн харилцааны хөгжилд сэтгэл хангалийн буйгаа илэрхийлэв. Энэхүү найрамдал, ах дүүсийн харилцааг нотолж, талууд 2020 онд дипломат харилцаа тогтоосны 65 жилийн ойг хоёр орны соёл, түүхэн нийтлэг өвийг онцолсон цуврал арга хэмжээ зохион байгуулан тэмдэглэхээр тохиролцов. Энэтхэгийн Засгийн газар энэхүү түүхэн ойг тэмдэглэх хүрээнд Монгол Улсад “Энэтхэгийн наадам”-ыг 2020 онд зохион байгуулахаа илэрхийлэв.
35. Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулгын төрийн айлчлал нь Монгол, Энэтхэгийн Стратегийн түншлэл болон урт хугацааны, найрсаг, нөхөрсөг харилцааг урагшлуулан хөгжүүлэхэд чиглэсэн чухал үйл явдал боллоо.

Эх сурвалж: Монгол Улсын Ерөнхийлөгчийн тамгын газрын сайт.

<https://president.mn/11029/> 2019.09.21